

## “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 8 сарын 11-ний өдөр

№ 21/34

Улаанбаатар хот

### Зөвшөөрөл олгох тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.5 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 2 сарын 13-ны А-45 дугаар тушаал, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн 2019 оны 12 сарын 25-ны 19/61 дугаар тогтоол, ТУЗ-ийн 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдсан охин компани болох “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг бүхэлд нь Компанийн толгой компани болох “АНД Системс” ХХК-д нийт 2,650,158,458.67 (Хоёр тэрбум зургаан зуун тавин сая нэг зуун тавин найман мянга дөрвөн зуун тавин найман төгрөг жаран долоон мөнгө) төгрөгөөр худалдахаар шийдвэрлэсүгэй.
2. “АНД Системс” ХХК-тай байгуулах “Супер Ап Хэтэвч” ХХК-ийн Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд “АНД Системс” ХХК-тай холбогдох гэрээ, хэлцлүүдийг байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах, энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасантай холбогдуулан “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг худалдахад шаардагдах аливаа хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг гаргах, баталгаажуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
4. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 2 сарын 13-ны А-45 дугаар тушаалаар батлагдсан “Цахим мөнгөний журам”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг худалдахыг зөвшөөрсөн энэхүү шийдвэрийн талаар Монголбанкинд албан ёсоор мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, үр дүнг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д даалгасугай.


### ТУЗ-ИЙН ГИШҮҮД



/С.БОРГИЛ/




/Ж.ЖАРГАЛСҮРЭН/




/С.ЭНХ-АМГАЛАН/



/Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/



/Б.ӨЛЗИЙБАЯР /



/Н.ЦЭВЭГМИД/